



**“МОН БИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурлыг хойшлуулах тухай**

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.3, 69.6, 69.7, 69.8, 69.9 дэх хэсэг, Тооллогын комиссын 2023 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Мон Бийф ХК-ийн 2023 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд *“компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцоогүй”* буюу хурлын ирц хүрээгүй тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн, хурлыг хойшлуулсугай.
2. Хойшлуулсан хурлын товыг 2022 оны 3 дугаар сарын 01-ний өдөр 14 цагт анх зарласан хэлбэрээр цахимаар зарлан хуралдуулсугай.
3. Хойшлуулсан хурлын хэлэлцэх асуудал, хурлын дэг, бүртгэлийн өдөр зэрэгт өөрчлөлт ороогүй болохыг дурдсугай.
4. Уг хурал хуралдахаас ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Хүчин төгөлдөр бус гэж үзсэн хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд оруулан тооцох болохыг мэдэгдсүгэй.
6. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал нь энэ тогтоолын 2 дахь хэсэг заасан хугацаанд хуралдаж чадаагүй бол шинээр хурал зарлах болохыг дурдсугай.
7. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалагч /С.Сайнбилэгт/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.БАРСБОЛД